

# СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: СЭА-2022/90-НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Сүхбаатар сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа	
	Утас: 70363040	Цахим хаяг: <a href="mailto:Enkhtuyach@audit.gov.mn">Enkhtuyach@audit.gov.mn</a>
	Аудитын менежер: Б.Батмөнх	
	Утас: 70363036	Цахим хаяг: <a href="mailto:Batmunkhb@audit.gov.mn">Batmunkhb@audit.gov.mn</a>
	Аудитор: З.Золбоо	
	Утас: 70362442	Цахим хаяг: <a href="mailto:Zolbooz@audit.gov.mn">Zolbooz@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1.Аудитын санал, дүгнэлт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	7
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	7
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	8
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	13
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14
3. Аудитын тайлан.....	15
3.1 Ерөнхий зүйл.....	15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	16
3.4 Материаллаг байдал .....	16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	17
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	18
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	19
3.8 Аудитын гол асуудал .....	20
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	20
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	20
3.10 Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт.....	21
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	21
4. Аудитын илрүүлэлт .....	21
4.1 Залруулсан алдаа .....	21
4.2 Зөвлөмж.....	21

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БТСГ	Биеийн тамир, спортын газар
БТСУХ	Биеийн тамир, спортын улсын хороо
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.23 № СЭА-2022/90-НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН БИЕИЙН  
ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН  
ДАРГА У.БАТМӨНХ ТАНАА

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА





## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>170,278,030.50</b>	<b>161,844,189.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>13,377,341.00</b>	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	13,120,000.00	-
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>257,341.00</b>	-
33510	Байгууллагаас авах авлага	167,173.00	-
33520	Хувь хүмүүсээс авах авлага	90,168.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>156,900,689.50</b>	<b>161,844,189.00</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>69,590,706.00</b>	<b>73,498,724.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	69,590,706.00	73,498,724.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>87,309,983.50</b>	<b>88,345,465.00</b>
35410	Бичиг хэргийн материал	4,819,260.00	4,226,960.00
35420	Аж ахуйн материал	49,794,410.00	51,877,322.50
35440	Түлш, шатах тослох материал	250,000.00	-
35450	Барилгын засварын материал	259,500.00	293,500.00
35470	Бусад хангамжийн материал	32,186,813.50	31,947,682.50
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>7,361,259,106.50</b>	<b>8,501,523,424.73</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>7,361,259,106.50</b>	<b>8,501,523,424.73</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>7,198,659,523.08</b>	<b>8,336,309,674.73</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,494,176,041.00	8,682,946,127.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(605,695,020.68)	(773,870,481.08)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	74,166,666.71	74,166,666.71
39204	Хуримтлагдсан элэгдэл	(34,600,463.08)	(15,461,574.28)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	307,120,139.00	295,966,844.82
39206	Хуримтлагдсан элэгдэл	(207,584,000.87)	(116,773,608.88)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	60,097,010.00	60,097,010.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(19,272,931.20)	(21,311,616.52)
39214	Бусад үндсэн хөрөнгө	195,842,259.17	235,140,189.17
39215	Хуримтлагдсан элэгдэл	(65,590,176.97)	(84,589,882.21)
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>162,599,583.42</b>	<b>165,213,750.00</b>
39301	Программ хангамж	2,035,000.00	3,535,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,495,416.58)	(381,250.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	162,060,000.00	162,060,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>7,531,537,137.00</b>	<b>8,663,367,613.73</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>103,560.00</b>	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>103,560.00</b>	-
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>103,560.00</b>	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	103,560.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>7,531,433,577.00</b>	<b>8,663,367,613.73</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>7,531,433,577.00</b>	<b>8,663,367,613.73</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн	1,086,045,198.00	1,086,045,198.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>6,059,927,107.29</b>	<b>7,191,861,144.02</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	6,158,920,589.18	6,059,927,107.29
51220	Тайлант үеийн үр дүн	(98,993,481.89)	1,131,934,036.73
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	385,461,271.71	385,461,271.71
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>7,531,537,137.00</b>	<b>8,663,367,613.73</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>867,867,485.00</b>	<b>2,652,716,484.35</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>119,803,025.00</b>	<b>1,388,308,181.23</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>119,803,025.00</b>	<b>1,388,308,181.23</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>-</b>	<b>19,713,601.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	19,713,601.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	116,553,025.00	1,368,194,580.23
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	3,250,000.00	400,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>748,064,460.00</b>	<b>1,264,408,303.12</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>-</b>	<b>587,545,100.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	587,545,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>57,501,500.00</b>	<b>12,977,200.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,012,800.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,771,700.00	12,977,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,717,000.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>690,562,960.00</b>	<b>663,886,003.12</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	690,562,960.00	663,886,003.12
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>966,860,966.89</b>	<b>1,520,782,447.62</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>966,860,966.89</b>	<b>1,520,782,447.62</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>947,488,466.89</b>	<b>1,458,946,957.82</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>266,915,556.00</b>	<b>436,413,816.52</b>
210101	Үндсэн цалин	219,567,220.00	362,682,889.34
210102	Нэмэгдэл	47,348,336.00	73,730,927.18
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>33,350,631.00</b>	<b>56,732,630.68</b>
210201	Тэтгэврийн даатгал	22,671,531.00	40,583,065.66
210202	Тэтгэмжийн даатгал	2,670,100.00	4,118,578.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,135,700.00	3,291,681.35
210204	Ажилгүйдлийн даатгал	534,100.00	794,674.68
210205	Эрүүл мэндийн даатгал	5,339,200.00	7,944,630.52
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>300,127,636.00</b>	<b>649,969,763.12</b>
210301	Гэрэл, цахилгаан	14,905,639.00	19,197,674.27
210302	Түлш, халаалт	264,351,152.00	608,374,613.85
210303	Цэвэр, бохир ус	20,870,845.00	22,397,475.00

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>27,455,600.00</b>	<b>22,283,789.50</b>
210401	Бичиг хэрэг	2,448,360.00	2,198,550.00
210402	Тээвэр, шатахуун	3,750,000.00	5,845,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,304,990.00	917,901.00
210404	Ном, хэвлэл	204,500.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,250,000.00	1,136,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,699,760.00	6,648,438.50
210408	Бараа материал акталсны зардал	9,797,990.00	5,537,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,246,635.00</b>	<b>-</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,244,635.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>20,342,000.00</b>	<b>22,628,790.00</b>
210604	Урсгал засвар	20,342,000.00	22,628,790.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>382,600.00</b>	<b>921,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	382,600.00	921,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,230,584.00</b>	<b>5,045,606.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,312,910.00	5,045,606.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,080,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	106,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	71,450.00	-
210807	Газрын төлбөр	160,224.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>288,437,224.89</b>	<b>264,951,562.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	52,711,160.00	23,121,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,210,500.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	234,515,564.89	241,830,262.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>19,372,500.00</b>	<b>61,835,489.80</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>19,372,500.00</b>	<b>49,612,700.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,482,500.00	46,637,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,890,000.00	2,974,900.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>12,222,789.80</b>
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	-	12,222,789.80
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>(98,993,481.89)</b>	<b>1,131,934,036.73</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(98,993,481.89)</b>	<b>1,131,934,036.73</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,086,045,198.00</b>	<b>385,461,271.71</b>	<b>6,158,920,589.18</b>	<b>7,630,427,058.89</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,086,045,198.00</b>	<b>385,461,271.71</b>	<b>6,158,920,589.18</b>	<b>7,630,427,058.89</b>
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
6	<b>Тайлант үеийн үр дүн</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>(98,993,481.89)</b>	<b>(98,993,481.89)</b>
7	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,086,045,198.00</b>	<b>385,461,271.71</b>	<b>6,059,927,107.29</b>	<b>7,531,433,577.00</b>
8	<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>1,086,045,198.00</b>	<b>385,461,271.71</b>	<b>6,059,927,107.29</b>	<b>7,531,433,577.00</b>
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
10	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,086,045,198.00</b>	<b>385,461,271.71</b>	<b>6,059,927,107.29</b>	<b>7,531,433,577.00</b>
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
12	Тайлант үеийн үр дүн	-	-	1,131,934,036.73	1,131,934,036.73
13	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,086,045,198.00</b>	<b>385,461,271.71</b>	<b>7,191,861,144.02</b>	<b>8,663,367,613.73</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН	
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>748,064,460.00</b>	<b>1,297,241,904.12</b>	
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>19,713,601.00</b>	
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	<b>19,713,601.00</b>	
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	-	<b>19,713,601.00</b>	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	19,713,601.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>748,064,460.00</b>	<b>1,277,528,303.12</b>	
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	<b>587,545,100.00</b>	
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	587,545,100.00	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>57,501,500.00</b>	<b>26,097,200.00</b>	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,012,800.00	-	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,771,700.00	12,977,200.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,717,000.00	13,120,000.00	
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>690,562,960.00</b>	<b>663,886,003.12</b>	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	690,562,960.00	663,886,003.12	
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>739,460,460.00</b>	<b>1,283,341,904.12</b>	
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>739,460,460.00</b>	<b>1,283,341,904.12</b>	
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>706,967,960.00</b>	<b>1,221,506,414.32</b>	
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>266,959,700.00</b>	<b>436,350,203.12</b>	
210101	Үндсэн цалин	212,368,913.15	362,619,275.94	
210102	Нэмэгдэл	54,590,786.85	73,730,927.18	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>33,370,100.00</b>	<b>56,732,631.08</b>	
210201	Тэтгэврийн даатгал	22,691,000.00	40,583,065.66	
210202	Тэтгэмжийн даатгал	2,670,100.00	4,118,578.47	
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,135,700.00	3,291,681.35	
210204	Ажилгүйдлийн даатгал	534,100.00	794,674.68	
210205	Эрүүл мэндийн даатгал	5,339,200.00	7,944,630.92	
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>300,127,636.00</b>	<b>649,969,763.12</b>	
210301	Гэрэл, цахилгаан	14,905,639.00	19,033,704.27	
210302	Түлш, халаалт	264,351,152.00	608,401,803.85	
210303	Цэвэр, бохир ус	20,870,845.00	22,534,255.00	
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>22,398,680.00</b>	<b>26,484,821.00</b>	
210401	Бичиг хэрэг	1,869,560.00	1,599,550.00	
210402	Тээвэр, шатахуун	4,000,000.00	5,595,100.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,304,990.00	917,901.00	
210404	Ном, хэвлэл	264,500.00	-	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,250,000.00	1,136,800.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,709,630.00	17,235,470.00	

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>2,850,000.00</b>	<b>-</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	850,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>20,342,000.00</b>	<b>23,066,790.00</b>
210604	Урсгал засвар	20,342,000.00	23,066,790.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>382,600.00</b>	<b>921,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	382,600.00	921,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,230,584.00</b>	<b>5,045,606.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,337,934.00	5,045,606.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,080,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	106,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	71,450.00	-
210807	Газрын төлбөр	135,200.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>51,306,660.00</b>	<b>22,935,600.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,096,160.00	22,935,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,210,500.00	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>32,492,500.00</b>	<b>61,835,489.80</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>19,372,500.00</b>	<b>49,612,700.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,482,500.00	46,637,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,890,000.00	2,974,900.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>12,222,789.80</b>
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	-	12,222,789.80
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>13,120,000.00</b>	<b>-</b>
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	13,120,000.00	-
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>8,604,000.00</b>	<b>13,900,000.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>8,604,000.00</b>	<b>13,900,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>8,604,000.00</b>	<b>13,900,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>8,604,000.00</b>	<b>13,900,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,604,000.00	13,900,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(8,604,000.00)</b>	<b>(13,900,000.00)</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/ төгрөгөөр /	
			Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,320,295,200.00</b>	<b>1,258,921,914.32</b>	<b>61,373,285.68</b>	<b>95.4%</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,320,295,200.00</b>	<b>1,258,921,914.32</b>	<b>61,373,285.68</b>	95.4%
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,270,682,500.00</b>	<b>1,209,309,214.32</b>	<b>61,373,285.68</b>	95.4%
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>439,691,000.00</b>	<b>436,350,203.12</b>	<b>3,340,796.88</b>	0.99
Үндсэн цалин	439,691,000.00	362,619,275.94	<b>77,071,724.06</b>	0.83
Нэмэгдэл		73,730,927.18	<b>(73,730,927.18)</b>	
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>59,358,200.00</b>	<b>56,732,631.08</b>	<b>2,625,568.92</b>	<b>95.6%</b>
Тэтгэврийн даатгал	41,770,600.00	40,583,065.66	1,187,534.34	97.2%
Тэтгэмжийн даатгал	4,396,900.00	4,118,578.47	278,321.53	93.7%
ҮОМШӨ-ний даатгал	3,517,500.00	3,291,681.35	225,818.65	93.6%
Ажилгүйдлийн даатгал	879,400.00	794,674.68	84,725.32	90.4%
Эрүүл мэндийн даатгал	8,793,800.00	7,944,630.92	849,169.08	90.3%
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>671,650,100.00</b>	<b>649,539,213.12</b>	<b>22,110,886.88</b>	<b>96.7%</b>
Гэрэл, цахилгаан	29,711,600.00	18,603,154.27	11,108,445.73	95.6%
Түлш, халаалт	608,446,800.00	608,401,803.85	44,996.15	95.6%
Цэвэр, бохир ус	33,491,700.00	22,534,255.00	10,957,445.00	95.6%
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24,112,200.00</b>	<b>24,112,171.00</b>	<b>29.00</b>	100%
Бичиг хэрэг	1,968,600.00	1,599,550.00	369,050.00	81.3%
Тээвэр, шатахуун	2,167,500.00	3,536,600.00	(1,369,100.00)	163.2%
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	612,500.00	917,901.00	(305,401.00)	149.9%
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,373,400.00	1,136,800.00	2,236,600.00	33.7%
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,990,200.00	16,921,320.00	(931,120.00)	105.8%
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>33,000,000.00</b>	<b>22,346,790.00</b>	<b>10,653,210.00</b>	<b>67.7%</b>
Урсгал засвар	33,000,000.00	22,346,790.00	10,653,210.00	67.7%
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>921,000.00</b>	<b>921,000.00</b>	-	<b>100%</b>
<b>Дотоод албан томилолт</b>	<b>921,000.00</b>	<b>921,000.00</b>	-	100%
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,550,000.00</b>	<b>6,545,606.00</b>	<b>4,394.00</b>	<b>99.9%</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,550,000.00	6,545,606.00	<b>4,394.00</b>	99.9%
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>35,400,000.00</b>	<b>12,761,600.00</b>	<b>22,638,400.00</b>	<b>0.36</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	35,400,000.00	12,761,600.00	22,638,400.00	0.36
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>49,612,700.00</b>	<b>49,612,700.00</b>	-	<b>100%</b>

Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,974,900.00	2,974,900.00	-	100%
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	46,637,800.00	46,637,800.00	-	100%
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,320,295,200.00</b>	<b>1,271,144,704.12</b>	<b>49,150,495.88</b>	<b>96.3%</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>588,245,100.00</b>	<b>587,545,100.00</b>	<b>700,000.00</b>	99.9%
Улсын төсвөөс санхүүжих	588,245,100.00	587,545,100.00	700,000.00	99.9%
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>696,650,100.00</b>	<b>663,886,003.12</b>	<b>32,764,096.88</b>	95.3%
Орон нутгийн төсвөөс	696,650,100.00	663,886,003.12	32,764,096.88	95.3%
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>35,400,000.00</b>	<b>19,713,601.00</b>	<b>15,686,399.00</b>	<b>55.7%</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,400,000.00	19,713,601.00	15,686,399.00	55.7%
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>57</b>	<b>57</b>		
Удирдах ажилтан	1	1		
Гүйцэтгэх ажилтан	27	27		
Үйлчлэх ажилтан	29	29		
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1	1		
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	56	56		

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>26,097,200.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>26,097,200.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>26,097,200.00</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		<b>430,550.00</b>
210301	Гэрэл, цахилгаан		430,550.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>2,372,650.00</b>
210402	Тээвэр, шатахуун		2,058,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		314,150.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>13,120,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		12,400,000.00
210604	Урсгал засвар		720,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>10,174,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		10,174,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>26,097,200.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		12,977,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		13,120,000.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг бүртгэж байхтай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор З.Золбоо гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Биеийн тамир, спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Биеийн тамир, спортын газар нь биеийн тамир спортыг орчин үеийн шинжлэх ухааны ололт, үндэсний уламжлалт ёс заншилд тулгуурлан хөгжүүлж, хүн амын эрүүл мэндийг бэхжүүлэн, бие бялдрын хүмүүжил олгон чийрэгжүүлж, эрүүл аж төрөх, хөдөлмөрлөх зорилгыг эрхэм болгон мэргэжлийн ур чадвартай өндөр зэрэгтэй тамирчид бэлтгэн гаргах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлсэн дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд

хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус газрын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд БТСУХ-ны “Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар”-аас хяналт шалгалт хийгдээгүй боловч тус газрын дотоод аудитын баг нь 2021 оны 3 дугаар улирлын байдлаар байгууллагын санхүү, бүртгэлийн зарим үйл ажиллагаа болон Шилэн дансны мэдээлэл байршуулалтад хяналт шалгалт хийж харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулах, шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлэх, 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн албан шаардлагын хэрэгжилтийг хангах чиглэлээр зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Биеийн тамир, спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 996,860.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 9,968.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7,476.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Биеийн тамир, спортын газрын 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,131,830.5 мянган төгрөгөөр буюу 15.0 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын оролцоо дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	13,377.3	-	(13,377.3)
Урьдчилгаа			
Бараа материал	156,900.7	161,844.2	4,943.5
Үндсэн хөрөнгө	7,361,259.1	8,501,523.4	1,140,264.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>7,531,537.1</b>	<b>8,663,367.6</b>	<b>1,131,830.5</b>
Өр төлбөр	103.5	-	(103.5)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7,531,433.6	8,663,367.6	1,131,934.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>7,531,537.1</b>	<b>8,663,367.6</b>	<b>1,131,830.5</b>

Авлагын данс үлдэгдэлгүй тайлагнагдсан нь оны эхний үлдэгдэл 13,377.3 мянган төгрөгөөс ажиллагсадтай холбоотой 167.1 мянган төгрөг, хувь хүнтэй холбоотой 90.2 мянган төгрөгийн, байгууллагатай холбоотой 13,120.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 161,844.2 мянган төгрөг болж өмнөх оноос 4,943.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 49,692.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон 400.0 мянган төгрөгийн 2 ширхэг автомат гар ариутгагчийг үнэ төлбөргүй хүлээн авч, 39,611.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулан, тус газрын даргын 2021 оны А/39 дүгээр тушаалаар 5,537.1 мянган төгрөгийн бараа материалыг акталж, данс бүртгэлээс хассанаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 9,513,911.8 мянган төгрөг болж өмнөх оноос 1,218,414.7 мянган төгрөгөөр өссөн нь 1,188,770.1 мянган төгрөгийн өртөг бүхий Алтанбулаг сумын спорт цогцолборын барилга, аймгийн ОНХС-ийн санхүүжилтээр хийгдсэн 39,297.9 мянган төгрөгийн таримал зүлэгтэй хөл бөмбөгийн талбай, БТСУХ-оос 2,390.5 мянган төгрөгийн хөрөнгө зэргийг тус бүр үнэ төлбөргүй хүлээн авч, данс бүртгэлд тусгасан болон төсвийн хөрөнгөөр

13,900.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 163,679.8 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хасан, элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны үнээ нөхсөн, цаашид ашиглах боломжтой хөрөнгийг 137,736.0 мянган төгрөгөөр үнэлж, бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 8,663,367.6 мянган төгрөг болж 1,131,934.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

Биеийн тамир спортын газрын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,748,849.0 мянган төгрөгөөр буюу 3.0 дахин өссөн нь тайлант онд Алтанбулаг, Баруунбүрэн, Баянгол, Ерөө, Шаамар, Дулаанхаан, Мандал, Сайхан, Цагааннуур сумдын 9 спорт цогцолборыг тус газрын харьяанд шилжүүлж, төсөв, санхүүжилт нь нэгтгэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант оны нийт зардал өмнөх оноос 553,921.5 мянган төгрөгөөр буюу 1.8 дахин өссөн нь сумдын 9 спорт цогцолборын 28 албан хаагчийн цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлууд шилжиж ирсэнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус газрын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг тус бүр 1,367,167.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг өөрчлөлгүйгээр эцэслэн баталсан байна.

Батлагдсан төсөвт 2021 оны 12-р сард БТСУХ-оос өөрчлөлт оруулан 46,871.9 мянган төгрөгөөр бууруулж, 1,320,295.2 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,320,295.2 мянган төгрөгийн төсөв баталж, 588,245.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 696,650.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 35,400.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 587,545.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 663,886.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 19,713.6 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлого бүрдүүлж, нийт 1,271,144.1 мянган төгрөгийн эх үүсвэрээс орж ирсэн байна.

Тайлант оны төсвөөс нийт 1,258,921.9 мянган төгрөгийг зарцуулж, 12,222.2 мянган төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлсэн бөгөөд төсвийн гүйцэтгэл 95.4

хувьтай тайлагнагдсан нь цалин, хөлс урамшууллын зардал 3,340.8 мянган төгрөг, НДШ 2,625.6 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардал 10,653.2 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 22,110.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 22,638.4 мянган төгрөг зэргээр тус тус хэмнэгдсэнээс шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

БТСУХ-ноос цахим фитнес төсөлд 13,120.0 мянган төгрөг, “Иргэдийн наадам- өртөөт марафон” арга хэмжээний зардалд 8,270.0 мянган төгрөг, “Дасгал хөдөлгөөн хийцгээе”-аяны арга хэмжээний зардалд 1,904.0 мянган төгрөг, аймгийн баяр наадмын зардлаас “Цэнгэлдэх хүрээлэнгийн зүлэг тарих, услах” зардалд 2,803.2 мянган төгрөгийн зэрэг нийт 26,097.2 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилт олгосон байна. Нэмэлт санхүүжилтийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 430.5 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 2,372.7 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 13,120.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 10,174.0 мянган төгрөгийг тус тус зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайлан орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2020 оны А/97 дугаар тушаалаар “Цахим фитнес төсөл”-д нийт 459,200.0 мянган төгрөгийг төсөвлөж аймаг, дүүргийн БТСГ, харьяа төвүүдийн дансанд тус бүр 13,120.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна. Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газар нь 2020 оны жилийн эцэст тус санхүүжилтийг аймгийн төрийн сангийн дансанд төвлөрүүлж, авлагаар бүртгэж байгаад 2021 оны 6 дугаар сард ухаалаг самбарын үнэ гэж “Санко Маркетинг Монголиа” ХХК-д 9,990.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

Дээрх худалдан авалтын нийт төсөвт өртөг нь шууд худалдан авах босго үнээс хэтэрсэн байх эрсдэлийг үүсгэж байгаа бөгөөд харьцуулалтын болон нээлттэй тендер шалгаруулалтаас зайлсхийх зорилгоор төсөвт өртгийг хувааж, харьяа БТСГ, төвүүдэд худалдан авах эрхийг шилжүүлсэн байж болзошгүй байна.

3.7.2 Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг **улсын төсөвт үйлдвэрийн газар** гэнэ”, Засгийн газрын 2019

оны 7 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын 3.1-д “Төрийн албан хаагчийн төрийн албанд ажилласан хугацаанд дараах хугацааг оруулан тооцно” 3.1.4: “Улсын төсөвт үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал, захиргааны ажилтан, бусад ажилтнаар 1996 оны 8 дугаар сарын 1-нээс 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдөр хүртэл ажилласан хугацаа” гэж зохицуулсан байдаг.

Гэтэл өндөр насны тэтгэвэр тогтоолгосон жижүүр Ц.Ганхуягт Материал техник хангамжийн удирдах газарт ажиллаж байсан 12 жилийн хугацаа, нягтлан бодогч А.Энхжаргалд Авто тээврийн удирдах газарт ажиллаж байсан 8 жилийн хугацааг тус тус төрийн албанд ажилласан хугацаанд оруулан тооцож, буцалтгүй тусламж олгохоор БТСУХ-оос хянаж, ирүүлсний дагуу нийт 46,637.8 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Энэ нь Материал техник хангамжийн удирдах газар, Авто тээврийн удирдах газрууд нь улсын төсөвт үйлдвэрийн газар мөн эсэх талаарх эрсдэл үүсгэж байгаа учир төрийн албанд ажилласан хугацааг үнэн зөв тодорхойлж, тэтгэмж олгох нь зүйтэй гэж үзэж байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Биеийн тамир, спортын газар нь шилэн дансны цахим хуудсанд 149 мэдээлэл байршуулахаас 146 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг (байгууллагын батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийг бүтэн жилээр) хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт

Биеийн тамир спортын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар төлбөр тооцоог урьдчилан хянаж авлага, өглөг үүсгэхгүй байх 270.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага өгөгдсөн бөгөөд тайлант онд албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	1	207.7	1	207.7	100
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>207.7</b>	<b>1</b>	<b>207.7</b>	<b>100</b>

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй болно.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 39,473.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1,240.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 38,233.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өглөө.

#### 4.1 Залруулсан алдаа

1. Тайлант онд шинээр бүртгэлд тусгасан 2 үндсэн хөрөнгөд 1,240.0 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулалгүй санхүүгийн тайланд тусгасныг залруулга хийлгэлээ.

#### 4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг аудитын зөвлөмжөөр хүргүүлэв. Үүнд:

##### 1.Төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тайлант онд 7,378.0 мянган төгрөгийн худалдан авалтын анхан шатны баримт нь бөөн дүнгээр шивэгдсэн, 30,855.4 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна. Цаашид холбогдох хууль, тогтоомжийн дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Сэлэнгэ аймгийн Биеийн тамир спортын газар	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
			Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	2	39,473.4	1	1,240.0	-	-	-	-	1	38,233.4